

# GLENVIEW СУРГУУЛИЙН 34-Р ДҮҮРЭГ

## АНХНЫ ТУСЛАМЖ, ОСОЛ, ЯАРАЛТАЙ ҮЕД МӨРДӨХ ДҮРЭМ ЖУРАМ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ

### Бага зэргийн гэмтэл

Сургуулийн эмч өнгөц гүвдрүү, шалбаралт, үрэлт гэх мэт хөнгөн гэмтлийг эмчилнэ. Энэ төрлийн ямар ч эмчилгээг эрүүл мэндийн алба тодорхой он, сар, өдөр, гэмтлийн шалтгаан бусад дэлгэрэнгүй мэдээллийг зохих ёсоор бүртгэж, тэмдэглэж авна. Багш, эцэг эхэд мэдэгдэх талаар зөв дүгнэлтийг гаргана.

### Мэргэжлийн эмчилгээ шаардлагатай байж болзошгүй гэмтэл

Зарим гэмтэл болох хугарал, хүнд хэлбэрийн шөрмөс суналт, мултрал, оёх шаардлагатай шарх гэх мэтийг эцэг эхэд мэдэгдэх шаардлагатай болдог. Сургуулийн эмч зохих анхны тусламжыг үзүүлж, дараах эмчилгээг нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатайгаар эцэг эхэд даалгана.

### Яаралтай мэргэжлийн эмчид хандах шаардлагатай ноцтой гэмтэл

Хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд мэргэжлийн эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай байж болзошгүй ноцтой гэмтлийг Glenview Paramedics-т үзүүлнэ. Энэ тохиолдолд эцэг эхэд нэн даруй мэдэгдэнэ. Хугарал, толгойны хүнд шарх, их хэмжээний цус алдалт, тархины доргилт гэх мэт хүнд хэлбэрийн гэмтэл авсан үед эрүүл мэндийн болон сургуулийн ажилтнууд онцгой нөхцөл байдлыг тодорхойлсоны дараа шийдвэр гаргаж яаралтай Glenview Paramedics-ийг дуудаж (911) хүүхдийг эмнэлэгт хүргэнэ.

Хүүхэд яаралтай тусламжын мэдэгдлийн хамт эмнэлэгт хүргэгдэж, шаардлагатай эмчилгээг эхлүүлнэ. Сургуулийн ажилтнууд, найз нөхөд, эсвэл хөршүүд хүүхдийг эмчлэх зөвшөөрлийг өгөхгүй. Түргэн тусламжын ажилтнууд гэмтэл авсан хүүхдийг эмнэлэгт хүргэх явцад эцэг эх эмнэлэг дээр уулзах боломжтой байх болно.

Эмнэлэг, эмч нарын үйл ажиллагаа явуулж байгаа одоогийн хууль тогтоомжид “Эм, мэс заслын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй эмнэлэг эсвэл эмч яаралтай эмчилгээ, анхны тусламж үзүүлдэг, эсхүл тусгай зөвшөөрөлтэй шүдний эмч хүүхдэд шүдний эмчилгээг яаралтай хийх бол, хэрэв эмч, шүдний эмч, эмнэлгийн шийдвэрийн дагуу хүүхдийн эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр тухайн нөхцөл байдалд зөвшөөрөл авах нь үндэслэлгүй гэж үзэж байгаа бол хүүхдийн эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчийн зөвшөөрлийг авах шаардлагагүй болно” гэжээ. 410 ILCS 210/3

***Би Glenview сургуулийн 34-р Дүүргийн анхны тусламж, ослын дүрэм, журмыг уншиж танилцсан. Эцэг эх, асран хамгаалагчийн хувьд доорхи нэр бүхий хүүхдийг мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй эмнэлгийн эмч, эмчилгээний яаралтай тусламжын үйлчилгээг хийж эхлүүлэхийг зөвшөөрч байна. Энэ нь эмчлэгч эмчийн үзэж байгаагаар эмчилгээг хойшлуулсан тохиолдолд түүний амь насанд аюул учирч, биеийн байдал өөрчлөгдөж, бэрхшээл үүсэх, хэт их өвчин мэдрэх байдал үүсэх зэрэг болзошгүй тохиолдолд хэрэгжинэ. Энэхүү эрх мэдэл бүхий зөвшөөрлийг надтай холбогдох хүчин чармайлт гаргасны дараа олгоно. Шаардлагатай анхны тусламжийг сургууль дээр хийж болно. Энэ зөвшөөрлийн хуудсыг зөвхөн миний байхгүй үед, онцгой байдлын үед эмчилгээг эхлүүлэх зөвшөөрөл олгох зорилгоор өөрийн хүсэлтийн дагуу бөглөж гарын үсэг зурсан болно.***

\_\_\_\_\_  
Хүүхдийн нэр (Үсгээр бичих)  
гарын үсэг

\_\_\_\_\_  
Эцэг эх / хууль ёсны асран хамгаалагчийн

\_\_\_\_\_  
Огноо